

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 474 дүгээр тогтоолоор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар байгуулагдаж, тус газрын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, орон тооны дээд хязгаарыг 150 байхаар тогтоосон бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Засгийн газрын 2022 оны 474-р тогтоолоор баталсан зохион байгуулалтын бүтцээр Үнэлгээ, мониторингийн баг, Хяналт шалгалтын баг, Тандалт судалгааны баг, Хуулийн баг гэсэн үндсэн чиг үүргийн 4 нэгж, Менежментийн баг, Дотоод хяналтын баг гэсэн дэмжих чиг үүргийн 2 нэгжтэйгээр, багийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байсан. Эдгээр нэгжүүдээс Тандалт судалгааны баг нь дотроо Үр дүнгийн шинжилгээний баг, Эрсдэлийн удирдлагын баг, Төлөвлөлт, зохицуулалтын баг гэсэн 3 нэгжтэйгээр ажиллаж байсан бол 2024 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтцийн нэгжийг 234 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

Ийнхүү Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар “Тогтоолд өөрчлөлт оруулах, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 234 дүгээр тогтоолд “Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталж, дүрмийн дагуу бүтцийн нэгжүүд газар болон зохион байгуулагдаж, нийт 7 газар, 8 хэлтэстэй байхаар өөрчлөлт орсон.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын зохион байгуулалтын бүтэц



